

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

НЭГ.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ

**Нэг.Зардал нэмэгдүүлэх саналыг, зардал бууруулах саналтай
хамт гаргах санал:**

Нэг.Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын урсгал зардлыг **300.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.Монгол Улсын Үндсэн хуулийн 30 жилийн ойг тохиолдуулан Улсын Бага Хурлын зарим гишүүдэд нэг удаагийн мөнгөн дэмжлэг олгоход зориулж 840.0 сая төгрөг, Ардын Их Хурлын депутатуудад буцалтгүй тусламж олгоход зориулж 2,350.0 сая төгрөг, Үндсэн хуулийн 30 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахад 200.0 сая төгрөг, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль батлагдахтай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангахад шаардагдах 1,562.8 сая төгрөгийн санхүүжилтийг, нийт **4,952.8** сая төгрөгийг Улсын Их Хурлын даргын урсгал зардалд нэмж тусгах;

3.Хүний эрхийн үндэсний комиссын урсгал зардлыг **1,664.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

4.“Монголын түүх, соёл, үндэсний урлагийг гадаад дотоодод түгээн сурталчлах төсөл хөтөлбөр”-ийг санхүүжүүлэхэд зориулж 400.0 сая төгрөг, аймаг, сум, нийслэл, дүүрэгт Номын баярыг уламжлал болгон хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт 1,000.0 сая төгрөг нийт **1,400.0** сая төгрөгийг Соёлын сайдын урсгал зардалд нэмж тусгах;

5.Санхүүгийн зохицуулах хорооны урсгал зардлыг **1,427.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

6.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцад тусгагдсан Шүүхийн сахилгын хорооны зардал болох 1,475.5 сая төгрөгийн санхүүжилтээс 1,000.0 сая төгрөгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн урсгал зардлыг нэмэгдүүлэхээр үлдээх, 475.5 сая төгрөгийг Шүүхийн сахилгын хорооны урсгал зардалд шилжүүлэх, мөн

хорооны урсгал зардалд 1,262.5 сая төгрөгийг нэмж тусган, нийт дүнгээр Шүүхийн сахилгын хорооны урсгал зардлыг 1,738.0 сая төгрөгөөр тооцож төсөлд тусгах;

Хоёр.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төслөөс хасах болон 2022 онд санхүүжих дүнг бууруулах санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан саналын томьёоллын 1 дүгээр хавсралт дахь 43,793.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2022 онд 20,842.4 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй, нийт 25 төсөл, арга хэмжээг төслөөс хасах;

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан саналын томьёоллын 1 дүгээр хавсралт дахь нийт 44 төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 38,708.0 сая төгрөгөөр бууруулах;

Гурав.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөлд шинээр нэмэх болон 2022 онд санхүүжих дүнг нэмэгдүүлэх санал:

1.Шүүхийн сахилгын хорооны хөрөнгийн зардалд 1,000.0 сая төгрөгийг тусгах;

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан саналын томьёоллын 2 дугаар хавсралт дахь 2022 онд 29,708.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, нийт 24 төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 28,642.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

3.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан саналын томьёоллын 2 дугаар хавсралт дахь 278,824.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2022 онд 104,211.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, нийт 106 төсөл арга хэмжээг төсөлд шинээр нэмэх;

Дөрөв.Дээрх саналуудтай үялдүүлэн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг зохицуулах санал:

1.Санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгагдсан арилжааны банкуудад олгох зээлийн хүүгийн татаасаас зохицуулах.

Санал гаргасан: Ч.Хүрэлбаатар, П.Анужин, Т.Аубакир,
Ж Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Х.Булгантуяа, С.Бямбацогт
Ж.Ганбаатар, Д.Ганбат, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар
Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг
Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг,
Б.Энхбаяр /цаашид "Ажлын хэсэг гэх"/

Тав.Төсвийн байнгын хорооны гишүүдээс санхүүжилтийн эх үүсвэрийг арилжааны банкуудад олгох зээлийн хүүгийн татаасаас зохицуулахаар гаргасан санал:

1.“Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 27,000.0 сая төгрөг 2022 онд санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг, “Дотуур байрын барилга 150 ор /Булган, Дашинчилэн сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он төсөвт өртөг 3,700.0 сая төгрөг санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг тус тус төсөлд нэмж тусгах;

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн

2.“Ахмадын хөгжлийн төв /Улаанбаатар, Багануур дүүрэг/ хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 950.0 сая төгрөг 2022 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг нэмж тусгах;

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

ХОЁР.2022 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛД НӨЛӨӨЛӨХГҮЙ САНАЛ.

Нэг.Урсгал зардлын дүнд нөлөөлөхгүй зохицуулалт хийх санал:

1.Байгаль, орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны төсвийн багц дахь “Ойжуулалт” хөтөлбөрт тусгагдсан 12.1 тэрбум төгрөгөөс 6.0 тэрбум төгрөгийг “Ойн хортон шавьж устгах” зориулалт арга хэмжээнд шилжүүлэх;

Санал гаргасан:Ажлын хэсэг

2.Эрүүл мэндийн сайдын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн “Улсын төсвөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт” зориулалт арга хэмжээнд тусгагдсан төсвийг 163.7 тэрбум төгрөгөөр бууруулж, “Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийг улсын төсвөөс төлөх шимтгэл” зориулалт арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг 163.7 тэрбум төгрөгөөр нэмэх;

Санал гаргасан:Ажлын хэсэг

3.Тэтгэврийн даатгалын сангаас 17,200.0 сая төгрөгийг Тэтгэмжийн санд шилжүүлэх;

Санал гаргасан:Ажлын хэсэг

Хоёр.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөх санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан нийт **43 төсөл** арга хэмжээний төсөвт өртгийг магадлалын

ерөнхий дүгнэлт болон нэг маягийн жишиг зураг төсвийг үндэслэн хавсралт 3-т тусгагдсанаар буюу **106,066.8** сая төгрөгөөр өөрчлөх.

Үүнд:

- 7,569.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2,769.3 сая төгрөгөөр бууруулах;
- 172,397.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 38 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 108,836.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

Санал гаргасан:Ажлын хэсэг

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын "XV.3.1.5 Хот хоорондын болон аймаг хоорондын зорчигч тээврийн авто буудал /Орхон, Баян-Өндөр сум/ хэрэгжих хугацаа 2022-2023 он төсөвт өртөг 3,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Батжаргал, Д.Батлут

Гурав.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил өөрчлөх санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан нийт **46 төсөл** арга хэмжээний нэр, хүчин чадал, байршлыг саналын томъёоллын 4 дүгээр хавсралтад тусгагдсанаар өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Дөрөв.2022 оны санхүүжих дүнд нөлөөлөхгүй, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хооронд зохицуулалт хийх болон хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж, урсгал зардлыг нэмэгдүүлэх санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын "XIX.1.57.Сумын шинэ болон хуучин эрүүл мэндийн төвийг холбох хүзүүвч /Архангай, Эрдэнэмандал сум/", хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 200.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 200.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасч, "Нүүдлийн өв соёлыг дэмжих хөтөлбөр /Архангай/" гэсэн хөтөлбөрийг санхүүжүүлэхээр Соёлын сайдын урсгал зардалд 200.0 сая төгрөгийг нэмж тусгах;

Санал гаргасан:Ажлын хэсэг

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын "V.1.3.2."Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн тоног төхөөрөмж /Ховд", хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасч, "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр" /Ховд/ гэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардалд 500.0 сая төгрөгийг нэмж тусгах;

Санал гаргасан:Ажлын хэсэг

3.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИ.1.124. Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Наранбулаг, Хяргас, Өндөрхангай, Завхан, Малчин сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 6,860.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 6,860.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг;

- Сумын төвийн тохижилт /Увс, Наранбулаг, Завхан сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг;

- Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Хяргас, Өндөрхангай, Малчин сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 4,860.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 3,175.0 сая төгрөг” гэсэн 2 төсөл арга хэмжээ болгон салгаж, зөрүү санхүүжилтээр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Үүнд:

- Дотуур байрын барилга, 100 ор /Увс, Ховд сум/, хэрэгжих хугацаа 2020-2022 он, төсөвт өртөг 1,885.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 585.0 сая төгрөг;

- Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум/, хэрэгжих хугацаа 2020-2022 он, төсөвт өртөг 1,250.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 100.0 сая төгрөг;

- Наадмын талбайн шинэчлэл /Увс, Хяргас сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 150.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 150.0 сая төгрөг;

- Хангилцагийн голын модон гүүр /Увс, Цагаанхайрхан сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 300.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 300.0 сая төгрөг;

- Баруун голын бетон гүүр, 10 у/м /Увс, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 300.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 300.0 сая төгрөг;

Мөн “Хөдөлмөр, халамж үйлчилгээний “Старт-апп” хөтөлбөр /Увс, Улаангом сум/ гэсэн төсөл, хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардалд 250.0 сая төгрөг нэмж тусгах.

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн

Тав.Саналын томъёололтой уялдуулан тооцооллын өөрчлөлтийг хүүлийн төсөлд тусгах санал:

1.Урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардал, орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс өгөх татаасын хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг тусгах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Зургаа.Саналын томъёололтой уялдуулан хувь зүйн техникийн өөрчлөлт хийх санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт дахь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд болон төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан, мөн хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Долоо. Ирээдүй өв санд төвлөрүүлэх орлоготой холбогдсон зарчмын санал:

1.Ирээдүй өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн хүснэгтийн “Зарлагын төрөл” гэсэн баганын “хуримтлуулах доод хэмжээ” гэсний өмнөх “Нэрийн дансанд” гэснийг хасах.

Найм.Найруулгын санал:

1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.2.2 дахь заалтын “Хэвлэмэл бүтээгдэхүүний” гэснийг “Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “хүсэлтийн барагдуулалт” гэснийг “хүсэлтийг шийдвэрлэх” гэж, 8 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн “сахин хамгаалах” гэснийг “хангах” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “бүрдүүлэлтийн хяналтаар хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын” гэснийг “бүрдүүлэлтэд хянагдсан хөрөнгө орлогын” гэж, мөн зүйлийн 10.1.2 дахь заалтын “Авилгын эсрэг” гэснийг “Авилгатай тэмцэх талаар” гэж, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “арга хэмжээ” гэснийг “хэрэгжүүлэх арга” гэж 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “аудитын мөрөөр гаргасан” гэснийг “аудитын гаргасан мөрөөр” гэж, мөн зүйлийн 12.2.1 дэх заалтын “илүүдэл орон тоог” гэснийг “орон тоог” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ёсоор гаргах” гэснийг “ёсны” гэж, мөн зүйлийн 13.4.1 дэх заалтын “үзүүлэлтээр хийх” гэснийг “үзүүлэлтээр хийх тайлангийн тоо” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын “санхүүгийн байдалд хяналт шалгалт хийх” гэснийг “санхүү, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” гэж, мөн зүйлийн 15.1.3 дахь заалтын “төрийн өмчит эзэмшилд” гэснийг “төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт” гэж, мөн зүйлийн 15.2.4 дэх заалтын “хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх” гэснийг “тодруулах” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын хүрэх түвшинг “0” гэснийг “1” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “яаралтай тусламжийн дуудлагын талаар хангасан бодит мэдээллийн” гэснийг “яаралтай тусламжийн бодит мэдээллийн” гэж, мөн зүйлийн 21.3.4 дэх заалтын “цахилгааны эх үүсвэрт холбох ажлыг үргэлжлүүлэх” гэснийг “цахилгааны эх үүсвэрт холбох ажил” гэж, мөн зүйлийн 21.4.1 дэх заалтын “хоригдлын хөдөлмөр эрхлэлт” гэснийг “хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах хоригдол” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “газрын зураглал, кадастр” гэснийг “газрын кадастр, зураглал” гэж, мөн зүйлийн 22.2.2 дахь заалтын “Төрийн архивыг цахимжуулах” гэснийг “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх” гэж, 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын

“Бодлогын баримт бичгүүдэд” гэснийг “Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд” гэж, 24 дүгээр зүйлийн 24.8.1 дэх заалтын “сургалтад хамрагдсан залуучууд, насанд хүрэгчдийн тухайн насны хүн амд эзлэх хувь” гэснийг “сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь” гэж, 25 дугаар зүйлийн 25.3.2 “нэгдсэн төвийн барилгын нэгдсэн зураг төсөл” гэснийг “нэгдсэн төвийн барилгын зураг төсөл” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын “давхардсан тоогоор нийт 24.8 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулж” гэснийг “мэдрэмтгий мал сүргийг хамруулах” гэж, мөн заалтын “хүрэх үр дүн хэсгийн “10” гэснийг “давхардсан тоогоор нийт 24.8 сая толгой мал, буурах хувь 10” гэж, мөн зүйлийн 28.1.4 дахь хэсгийн “мялзан өвчингүй тайван байдлыг хадгална” гэснийг “мялзан өвчингүй байх” гэж, мөн зүйлийн 28.2.1 дэх заалтын “га-гийн ургацыг” гэснийг “1 га-гаас авах ургацыг” гэж тус тус өөрчлөх;

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 15, 6 дугаар зүйлийн 26 дахь заалт, төслийн 1 дүгээр хавсралтын 26.1 дэх хэсгийн “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд” гэснийг “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд” гэж өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Ес.Монгол Улсын Их Хурлын чүүлганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хийх хуулийн өөрчлөлтүүд:

1.“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

2.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан тооцоололтой холбоотойгоор Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

3.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан тооцоололтой холбоотойгоор “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 53 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

4.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан тооцоололтой холбоотойгоор Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР БУСАД БАЙНГЫН
ХОРООНООС ИРҮҮЛСЭН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

НЭГ.ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН САНАЛ

1.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХII.1.108. Найрамдал төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1, 3, 4 дүгээр хороо/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 400.0 сая төгрөг, санхүүжих дүн 400.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 100.0 сая төгрөгөөр бууруулж, “Орон нутгийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж, эрүүл хүнс төсөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 100.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 100.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа
/БОХХААБХ дэмжсэн санал/**

2.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХVII.1.29. Зоорийн байгууламж /Сэлэнгэ, Сант сум/” гэсэн төсөл, арга хэмжээний “Сант сум” гэснийг “Мандал сум” гэж өөрчлөх;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн
Д.Өнөрболор /БОХХААБХ дэмжсэн санал/**

3.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХII.1.94. Гэр хорооллын гадна дулаан, усан хангамжийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ, Дэнж баг/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасч, “Боловсролын салбарын Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар
/БСШУСБХ дэмжсэн санал/**

4.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХIII.1.1.316. Цэцэрлэгийн барилга худалдаж авах, 100 ор /Завхан, Улиастай сум, Жинст баг/, хэрэгжих хугацаа 2022-2023 төсөвт өртөг 1,239.1 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасч, үүнтэй холбоотойгоор нэгд,

“Яруугийн хүрээнд мод тарьж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах төсөл /Завхан, Алдархаан сум/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 270.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 270.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, хоёрт “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдол арилгахад шаардлагатай тоног төхөөрөмж /Завхан/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 130.0 сая төгрөг, санхүүжих дүн 130.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах, гуравт, “XIII.1.1.105.Сургуулийн дотуур байрны барилга /Завхан, Улиастай сум/ хэрэгжих хугацаа 2021-2022 он, төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2022 онд санхүүжих дүнг тус тус 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан
/БСШУСБХ дэмжсэн санал/**

5.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIII.1.1.279.Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Улиастай сум, 5 дугаар баг/, хэрэгжих хугацаа 2022-2024, төсөвт өртөг 8,157.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 400.0 сая төгрөгөөр бууруулж, “XIII.1.1.105.Сургуулийн дотуур байрны барилга /Завхан, Улиастай сум/ хэрэгжих хугацаа 2021-2022 он, төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2022 онд санхүүжих дүнг тус тус 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан
/БСШУСБХ дэмжсэн санал/**

6.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIII.1.3.24. Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий/” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1,2,3,4,5,6,8 дугаар сургууль/” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен
/БСШУСБХ дэмжсэн санал/**

7.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн “XIII.1.1.2.Бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тыва бага сургууль/, хэрэгжих хугацаа 2019-2023 он, төсөвт өртөг 1,200.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 764.9 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,182.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен
/БСШУСБХ дэмжсэн санал/**

8.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIII.1.1.291. Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/, хэрэгжих

хугацаа 2022-2023 он” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийн “Барилгын өргөтгөл” гэснийг “Барилга” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен
/БСШУСБХ дэмжсэн санал/**

9.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИХ.3.17. Эрүүл мэндийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 115.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 115.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасч нэгд, “Эрүүл мэндийн төвийн зөөврийн “ЭХО” аппарат /Баян-Өлгий, Бугат, Баяннуур, Толбо сум/, хэрэгжих хугацаа 2022 он, төсөвт өртөг 72.0 сая төгрөг, санхүүжих дүн 72.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг, хоёрт, “Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Баян-Өлгий, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2022 он, төсөвт өртөг 23.0 сая төгрөг, санхүүжих дүн 23.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, гуравт “Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2022 он, төсөвт өртөг 20.0 сая төгрөг, санхүүжих дүн 20.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд тус тус нэмэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен
/НББХ дэмжсэн санал/**

10.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИХ.3.26. Эрүүл мэндийн явуулын үзлэгийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 1,400.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,400.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг тус бүр 600.0 сая төгрөгөөр бууруулж, “Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 600.0 сая төгрөг, санхүүжих дүн 600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын
гишүүн С.Одонтуяа
/НББХ дэмжсэн санал/**

11.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИХ.3.16. Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг тус бүр 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг, 2022 онд санхүүжих дүн тус бүр 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа,
Ц.Туваан, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн, Б.Бейсен,**

**П.Анужин, С.Ганбаатар, Ч.Ундрaм, Б.Баярсайхан
/НББХ дэмжсэн санал/**

12.Эрүүл мэндийн сайдын 2022 оны төсвийн төслийн “Улсын төсвөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт зориулалт арга хэмжээнд тусгагдсан төсвийг 163.7 тэрбум төгрөгөөр бууруулж, Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийг улсын төсвөөс төлөх шимтгэл зориулалт арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг 163.7 тэрбум төгрөгөөр нэмэх;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг
/НББХ дэмжсэн санал/**

13.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИХ.1.29. Эрүүл мэндийн төвийн барилга 15 ор /Өмнөговь аймаг, Сэрвэй сум/, хэрэгжих хугацаа 2021-2023 он төсөвт өртөг 1,650.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,502.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ
/НББХ дэмжсэн санал/**

14.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХИИ.1.1.256.Дотуур байрны барилга, 100 ор /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ хэрэгжих хугацаа 2022-2024 он,” төсөвт өртөг 2,880.1 сая төгрөг 2022 онд санхүүжих дүн 240.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 140.0 сая төгрөгөөр, “ХИХ.1.68. “Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Хөвсгөл, Ар булаг сум/, хэрэгжих хугацаа 2022-2024 он, төсөвт өртөг 1,418.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 200.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 100.0 сая төгрөгөөр, “ХVII.1.28. Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Эрдэнэбулган, Тосонцэнгэл, Рашаант, Галт, Бүрэнтогтох, Арбулаг, Их-Уул, Цагаан-Уул, Төмөрбулаг, Түнэл сум/” хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 200.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 200.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 100.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, “Төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 340.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 340.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Л.Мөнхбаатар /ТББХ дэмжсэн санал/**

15.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 15, 6 дугаар зүйлийн 26 дахь заалт, төслийн 1 дүгээр хавсралтын 26.1 дэх хэсгийн “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд” гэснийг “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд” гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал
/УББХ дэмжсэн санал/**

16.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын Эрчим хүчний сайдын багцын "XVIII.1.44.Шинэ нисэх-Зуунмод сумыг холбох 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц /Төв, Зуунмод сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 9,593.4 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 4,796.7 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг "18,648.6 сая төгрөг" гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Ж.Батжаргал
ҮББХ дэмжсэн санал/**

17.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын "XVII.3.24.Хөдөө аж ахуйг дэмжих тоног төхөөрөмж /Төв/", гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг "Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Төв аймаг, 27 сум/" гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан
ҮББХ дэмжсэн санал/**

18.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын "Х.4.1.5 Хилийн анги шинээр байгуулах /Хөвсгөл, Баянзүрх сум/" гэсэн төсөл арга хэмжээний "Баянзүрх сум" гэсэн нэрийг "Цагаан-Уул сум" гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Л.Мөнхбаатар /ХЗБХ дэмжсэн санал/**

19.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын "Х.3.1.2. Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн байр /Баян-Өлгий, Өлгий сум/", хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 6,200.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,340.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 340.0 сая төгрөгөөр, "Х.3.1.3.Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн байр /Ховд, Жаргалант сум/" хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 6,300.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,300.0 сая төгрөг, гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 300.0 сая төгрөгөөр, "Х.4.1.2.Хил хамгаалах ерөнхий газрын өргөтгөл, Шуурхай удирдлагын төв, Хилийн цэргийн төв архивын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 6,500.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих 3,250.0 сая төгрөг" гэсэн төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 250.0 сая төгрөгөөр, "Х.4.1.5.Хилийн анги шинээр байгуулах /Хөвсгөл, Баянзүрх сум/" хэрэгжих хугацаа 2022-2024, төсөвт өртөг 8,339.1 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,400.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 400.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, "Цагдаагийн газрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 5,400.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,290.0 сая төгрөг" гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа
/ХЗБХ дэмжсэн санал/**

20.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “Х.4.2.2. Хилийн 0306 дугаар ангийн Бага хүрээ салбарын их засвар /Дорнод, Матад сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 510.1 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 510.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасч, “Х.4.2.3.Хилийн 0287 дугаар ангийн заставын барилгын их засвар /Хэнтий, Дадал сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 510.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 510.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасч, “Х.5.2.1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 5,807.5 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 5,807.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,779.9 сая төгрөгөөр мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2022 оны урсгал зардлыг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, “Хилийн 0200 дугаар ангид нисдэг онгоц худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 6,800.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 6,800.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмж тусгах;

Тайлбар:Дээрх 20 дугаар саналыг зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд дараах байдлаар хураалгаж дэмжигдсэн болно.

20.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “Х.4.3.1. Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2021-2024 он, төсөвт өртөг 17,325.4 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 5,275.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 1,020.1 сая төгрөгөөр, “Х.5.2.1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 5,807.5 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 5,807.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,779.9 сая төгрөгөөр, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 2022 оны урсгал зардлыг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, “Хилийн 0200 дугаар ангид нисдэг онгоц худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 6,800.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 6,800.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа
/ХЗБХ зарчмын хувьд дэмжсэн санал/**

21.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “Х.5.2.1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2022-2022 он төсөвт өртөг 5,807.5 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 1,569.5 сая төгрөгөөр бууруулж, “Х.6.1.4.Цагдаагийн хэлтсийн барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/” хэрэгжих хугацаа 2021-2023 он, төсөвт өртөг 3,380.3 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,048.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 3,666.4 сая төгрөг гэж, 2022 онд санхүүжих дүнг 2,617.9 сая төгрөг гэж, хэрэгжих хугацааг 2021-2022 гэж тус тус өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Б.Жаргалмаа
/ХЗБХ дэмжсэн санал/**

22.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХII.4.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2020-2022 он төсөвт өртөг 67,900.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 35,927.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, “ХII.1.142.Хороо, дүүргийн орчныг тохижуулах “Жишиг хороо” төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,000.0 сая төгрөг, санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр, ХII.2.33.Орон сууцны гадна фасад, дулаалга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 6, 15, 16, 18, 25 дугаар хороо/ хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,000.0 сая төгрөг, санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр тус тус нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр
/ЭЗБХ дэмжсэн/**

23.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “ХII.1.115.Сум, аймгийн төвийн гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 10,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 10,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 7,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төсөл /Төв/, хэрэгжих хугацаа 2022-2024 он, төсөвт өртөг 33,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 4,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээ болон “Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 9,319.4 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг тус тус нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг
/ЭЗБХ дэмжсэн санал/**

24.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “V.1.3.8.Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Орхон/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 400.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 400.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 200.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, “Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 200.0 сая төгрөг, санхүүжих дүн 200.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг шинээр нэмж тусгах;

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖЭЭГҮЙ САНАЛ

1.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIV.1.5. Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ хэрэгжих хугацаа 2022-2024 он, төсөвт өртөг 94,460.1, 2022 онд санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, “Сумын төвийн тохижилт /Дорноговь, Замын-Үүд сум/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 500.0 сая, 2022 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөг”, мөн “Цэвэр усны нөөц сан /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2022-2023 он, төсөвт өртөг 2,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн хоёр төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан,
Т.Энхтүвшин /БОХХААБХ дэмжсэн санал/**

2.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “V.1.2.2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 9,503.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 9,503.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон 2022 онд санхүүжих дүнг тус бүр 400.0 сая төгрөгөөр бууруулж, “Үүрэн сүлжээний антен 2 ширхэг /Ховд аймаг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг болон 2022 онд санхүүжих дүн тус бүр 400.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн
Б.Пүрэвдорж
/ТББХ дэмжсэн санал/**

3.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIV.1.5. Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2024 он” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Дижитал-Эрдэнэт төсөл /Орхон/ хэрэгжих хугацаа 2021-2023 он, төсөвт өртөг 10,000.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж
/ТББХ дэмжээгүй санал/**

4.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын урсгал зардлыг 1,995.3 сая төгрөгөөр бууруулж, “Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2022 оны урсгал зардлыг 1,664.6 сая төгрөгөөр” нэмэгдүүлж, мөн “Хүний эрхийн үндэсний комиссын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 330.7 сая төгрөг, санхүүжих дүн 330.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд шинээр нэмж тусгах;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг,
Д.Цогтбаатар
/ХЗБХ дэмжсэн санал/**

5.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “VIII.1.1.Бээжин дэх элчин сайдын яамны Монголын соёл мэдээллийн төвийн барилга” хэрэгжих хугацаа 2022-2022 он, төсөвт өртөг 1,600.0 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 1,600.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 750.0 сая төгрөгөөр бууруулж, Хүний эрхийн үндэсний комиссын урсгал зардлыг 750.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа,
Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Ц.Мөнхцэцэг
/ХЗБХ дэмжээгүй санал/**

6.Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтын “XIV.1.5 Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2024 он, төсөвт өртөг 94,460.1 сая төгрөг, 2022 онд санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр, хуулийн төслийн 3 дугаар хавсралтад “1.1.1.3.Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам” гэсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг 15,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлын цалин, хөлс болон нэмэгдэл, урамшуулал гэсэн зардлыг 20,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж
/ХЗБХ дэмжээгүй санал/**

